НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/98/НА-СТА-ОНӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас:315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитор: Д.Мөнхдэлгэр
Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 9

4. АУДИТЫН ТАЙЛАН 12

4.1 Ерөнхий зүйл 14

4.2 Материаллаг байдал 14

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ҢИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025 03.14 № 01/322
танай -ны № -т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ЖАВХЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус газар нь зорилтот түвшний орлогыг 18,125.5 сая төгрөгөөр төлөвлөж, 86.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 28 дугаар тогтоолоор шинээр байгуулж, 6 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулсан байна.

Бусад асуудал

Тайлант онд байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

1425010186

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлэзд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		7 сарын 31	12 сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	640,000,000.00	455,396,845.29
1.1.02	Дансны авлага	135,324,348.49	2,536,308,802.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	139,083.62
1.1.04	Бусад авлага	19,434,068.93	12,272,708.15
1.1.06	Бараа материал	306,020,555.35	1,176,249,940.12
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**1,100,778,972.77**	**4,180,367,379.18**
1.2.01	Үндсэн хөрөнгө	28,533,686,429.11	30,125,287,329.45
1.2.02	Биет бус хөрөнгө	0.00	13,090,000.00
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**28,533,686,429.11**	**30,138,377,329.45**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**29,634,465,401.88**	**34,318,744,708.63**
2.1.1.01	Дансны өглөг	0.00	1,365,499,871.76
2.1.1.02	Цалингийн өглөг	572,903,084.02	44,852,939.45
2.1.1.03	Татварын өр	78,425,378.49	312,806,023.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	228,114,530.99	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	879,442,993.50	1,723,158,834.21
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	28,096,459,496.00	26,909,227,609.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	28,096,459,496.00	26,909,227,609.00
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**28,975,902,489.50**	**28,632,386,443.21**
2.3.01	Өмч: - төрийн	658,562,912.38	658,562,912.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	2,228,166,667.20
2.3.09	Хуримтлагдсан ашиг	0.00	2,799,628,685.84
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	2,799,628,685.84
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**658,562,912.38**	**5,686,358,265.42**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**29,634,465,401.88**	**34,318,744,708.63**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	**Борлуулалтын орлого (цэвэр)**	**0.00**	**15,494,204,043.00**
02	**Борлуулалтын өртөг**	**0.00**	**9,881,694,014.53**
03	**Нийт ашиг(алдагдал)**	**0.00**	**5,612,510,028.47**
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	8,571,113.45
05.1	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	100,357,632.95
08.1	**Орлогын дүн**	**0.00**	**108,928,746.40**
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.00	2,602,378,554.68
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	6,625,511.35
12.1	**Зардлын дүн**	**0.00**	**2,609,004,066.03**
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)**	**0.00**	**3,112,434,708.84**
19	**Орлогын татварын зардал**	**0.00**	**312,806,023.00**
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**0.00**	**2,799,628,685.84**
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**0.00**	**2,799,628,685.84**
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**0.00**	**12,652,698,277.89**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	2,011,494,871.49
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	51,991,267.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	10,532,274,660.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	56,937,479.40
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**0.00**	**12,837,301,432.60**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.00	6,552,160,520.87
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.00	871,454,254.15
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	222,369,420.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	39,721,851.11
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	3,389,669,778.12
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.00	10,656,745.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	40,075,980.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	0.00	1,711,192,883.35
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**0.00**	**-184,603,154.71**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**0.00**	**0.00**
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**0.00**	**0.00**
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**0.00**	**0.00**
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**0.00**	**0.00**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	**0.00**	**0.00**
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**0.00**	**0.00**
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**0.00**	**0.00**
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**0.00**	**0.00**
4.1	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**0.00**	**-184,603,154.71**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**640,000,000.00**	**640,000,000.00**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**640,000,000.00**	**455,396,845.29**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	**2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл**	**658,562,912.38**	**0.00**	**0.00**	**658,562,912.38**
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
09	**2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл**	**658,562,912.38**	**0.00**	**0.00**	**658,562,912.38**
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,799,628,685.84	2,799,628,685.84
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	2,228,166,667.20	0.00	2,228,166,667.20
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	**2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл**	**658,562,912.38**	**2,228,166,667.20**	**2,799,628,685.84**	**5,686,358,265.42**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	**Нийт орлого**	**18,125,529,800**	**15,594,561,675**	**2,530,968,125.0**	**86.0**
1.1	Шугамын орлого	906,276,500	758,265,743	148,010,757.0	**83.7**
1.2	Татаас, санхүүжилтийн орлого	15,406,700,300	13,620,538,500	1,786,161,800.0	**88.4**
1.3	Нөхөн олговор	1,812,553,000	1,115,399,800	697,153,200.0	**61.5**
1.4	Бусад орлого		100,357,632	-100,357,632.0	
1.5	Хүүний орлого		8,571,113	-8,571,113.5	
2	**Нийт зардал**	**19,359,891,480**	**12,796,878,592**	**6,563,012,888.4**	**66.1**
2.1	Цалин	7,440,991,440	5,404,729,514	2,036,261,926.2	72.6
2.2	НДШ	1,078,943,740	871,762,655	207,181,085.2	80.8
2.3	Хоол, Унаа	433,620,000	323,023,000	110,597,000.0	74.5
2.4	Шатахуун	4,891,648,200	3,960,142,409	931,505,791.5	81.0
2.5	Тосолгооны материал	396,199,500	82,514,192	313,685,308.2	20.8
2.6	Сэлбэг хэрэгсэл	991,205,000	106,980,763	884,224,237.5	10.8
2.7	Дугуйн зардал	230,000	-	230,000.0	0.0
2.8	Хөдөлмөр хамгаалал	1,120,020,400	1,305,528	1,118,714,871.8	0.1
2.9	Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,264,923,000	1,279,927,608	-15,004,608.3	101.2
2.1	Бичиг хэрэглэл	18,621,000	11,483,220	7,137,780.5	61.7
2.11	Багаж хэрэгсэл	87,786,400	-	87,786,400.0	0.0
2.12	Хангамжийн материал	45,500,000	123,300,729	-77,800,729.2	271.0
2.13	Цахилгаан	53,781,500	-	53,781,500.0	0.0
2.14	Ус	14,913,500	-	14,913,500.0	0.0
2.15	Халаалт дулаан	274,861,700	23,290,000	251,571,700.0	8.5
2.16	Харилцаа холбоо	47,305,000	1,590,171	45,714,828.9	3.4
2.17	Үндсэн хөрөнгийн татвар	7,635,800	-	7,635,800.0	0.0
2.18	Газрын төлбөр	18,683,800	-	18,683,800.0	0.0
2.19	Тээврийн хэрэгслийн татвар (гэрчилгээ, дугаар)	10,761,300	10,656,745	104,555.0	99.0
2.2	Даатгалын үйлчилгээ	35,670,200	40,075,980	-4,405,780.0	112.4
2.21	Сургалт, сурталчилгаа	39,280,000	19,450,000	19,830,000.0	49.5
2.22	Албан томилолт	42,300,000	-	42,300,000.0	0.0
2.23	Ажилчдын нийгмийн зардал	495,000,000	16,624,017	478,375,983.0	3.4
2.24	Гадны үйлчилгээ	310,240,000	134,140,535	176,099,465.0	43.2
2.25	Үйл ажиллагааны бусад	10,000,000	380,523,827	-370,523,827.0	3,805.24
2.26	Шагнал урамшуллын зардал		140,000	-140,000.0	
2.27	Засвар үйлчилгээний зардал		5,217,700	-5,217,700.0	
2.28	Банкны шимтгэл		114,000	-114,000.0	
2.29	**Үйл ажиллагааны бусад зардал**		**6,625,511**	**-6,625,511.4**	
3	**Үндсэн бус үйл ажиллагааны ашиг**		**1,945,602**	**-1,945,602.1**	
4	**Ашиг, алдагдал**	**(1,234,361,680)**	**2,799,628,685**		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын дүрмийн 1.1-д "өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө, энэхүү дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүгийн замаар бие даан иргэний гүйлгээнд ордог нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч үйлчлүүлэх эрэлт, хэрэгцээг хангах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн-газар мөн" гэж тодорхойлсон.

Тус газар нь үйл ажиллагааны зорилгоо "Нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн зорчигч-тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх чанар, үр дүнг дээшлүүлэх иргэдэд шуурхай, боловсон ая тухтай үйлчлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх үйлчилгээний менежементийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвлөгөө тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын-жишигт хүргэх" гэж тодорхойлон дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийг үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн хэрэгслээр хүргэх;
- Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн-төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих;
- Үйл ажиллагаа явуулахад шаардагдах хүний нөөц (инженер, мэргэшсэн жолоо-засварчин)-ийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын-үйл ажиллагаа явуулах;
- Улаанбаатар хотын нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ашиглалтын ажлыг удирдан зохион байгуулах.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 28 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах-бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5-д хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах..." гэж заасантай нийцэж байна.

ОНӨААТҮГ-ын удирдлагыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч-томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн-18.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн-газрын Захирал удирдана. Захирлыг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргаанд-байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох бөгөөд-өөрчилнө;..." гэж заасантай нийцэж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 28 дугаар тогтоолоор "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тус байгууллагын Удирдах зөвлөлийг шинээр томилогдох хүртэл хугацаанд үүсэн гүйцэтгэх эрх олгосон байна. Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.1-д заасны дагуу удирдах зөвлөлийг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Удирдах-зөвлөлийн хурлыг 2024 онд 1 удаа зохион байгуулж, 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталгаажуулсан байна.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдсан;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт орсон;
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай";
- НЗД-ын А/290 дүгээр захирамж "Машин цагийн зардлын зардлыг шинэчлэн батлах тухай".

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын захирлын 2024 оны А/34 дүгээр тушаалаар 4 орон тоотой, дотоод хяналт, шалгалтын хэлтэстэй ажиллахаар баталсан, тайлант онд орон тоо бүрдээгүй байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүгийн чиг үүргийг удирдах болон дээд шатны ажилтнууд хэрэгжүүлдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ нь "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, тус газрын үйл ажиллагааны онцлогт тохируулан, шинээр боловсруулж санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуй нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн эхлэлтийн дүнгээс 4,684,279.3 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 7-р сарын 31	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	640,000.0	455,396.8	(184,603.2)

Авлага	154,758.4	2,548,720.6	2,393,962.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	306,020.6	1,176,250.0	870,229.4
Үндсэн хөрөнгө	28,533,686.4	30,138,377.3	1,604,690.9
Нийт хөрөнгө	**29,634,465.4**	**34,318,744.7**	**4,684,279.3**
Өр төлбөр	28,975,902.5	28,632,386.4	(343,516.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	658,562.9	5,686,358.3	2,263,962.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**29,634,465.4**	**34,318,744.7**	**4,684,279.3**

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага,бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 455,396.8 мянган төгрөг болж 184,603.2 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны зардлуудыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 2,548,720.6 мянган төгрөг болж, 2,393,962.2 мянган төгрөгөөр өссөн нь 2025 оны 1 дүгээр сарын санхүүжилтийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,176,250.0 мянган төгрөг болж 870,229.4 мянган төгрөгөөр өссөн нь 5,155,841.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 4,282,551.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын үлдэгдэл нөөцийн 24.4 хувийг түлш шатах тослох материал, 22.3 хувийг сэлбэг хэрэгсэл, үлдсэн 53.3 хувийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай тусгай зориулалтай хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, бичиг хэрэг бусад хангамжийн материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 30,138,377.3 мянган төгрөг болж 1,604,690.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдаж авсан 493,261.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, НЗД-ын 2024 оны А/1110 захирамжийн дагуу бүртгэлд шилжүүлэн авсан 2,228,166.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг тус тус хөрөнгийн орлогод авч 1,279,927.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна. Биет бус хөрөнгөд 13,860.0 мянган төгрөгийн программ хангамж нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 28,632,386.4 мянган төгрөг болж 343,516.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны 7 дугаар сарын тооцоолсон цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 756,164.6 мянган төгрөг, бусад урт хугацаат өр төлбөрийн 1,187,231.3 мянган төгрөгийг төлж барагдуулсанаас шалтгаалжээ. Нийт өр төлбөрийн 94.0 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,686,358.3 мянган төгрөг болж, 2,263,962.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу газрын удирдлага нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохион байгуулллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 18,125,529.5 мянган төгрөг, нийт зардлыг 19,359,891.2 мянган төгрөг, 1,234,361.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 1,974,023.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 13,620,538.5 мянган төгрөгийн татаас санхүүжилт авч, 12,794,933.0 мянган төгрөгийн зардал гарган, 2,799,628.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 15,594,561.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,530,968.1 мянган төгрөг буюу 14.0 хувиар дутуу биелсэн нь 5 тээврийн хэрэгслийг Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-т шилжүүлснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 12,796,878.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 6,563,012.9 мянган төгрөг буюу 34.0 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь батлагдсан орон тоо дутуу ажилласан, цахилгаан, ус дулааны зардалд төлбөр төлөөгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,799,628.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,565,267.0 мянган төгрөгөөр илүү байгаа нь орон тоо бүрэн ажиллаагүйгээс цалинтай холбоотой зардал, зарим бусад зардал гараагүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зорчигч тээвэр дөрөв ОНӨААҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаас илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаас анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтлөх авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Ё.Лхагвадулам, аудитор Д.Мөнхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангаа НТАГ-т 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/04/125 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан зорилтот түвшин, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны зорилтот түвшний нийт зардлын 19,359,891.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 290,398.4 мянган төгрөгөөр тогтоосны аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад хөрөнгийн худалдан авалт, зардлыг гаргахгүй байхаар батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажилласан байна.

Зорчигч тээвэр ОНӨААТҮГ нь тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт хүргүүлээгүй, албан хэрэгцээнд 36,846.0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий 10 аж ахуй нэгжээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д *"Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д заасныг хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ"*, 14.4-д *"Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"* заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээний нөхцөл үүссэн үед захиалгын хүсэлтийг илгээж, бараа материал, хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 978,979.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 65,191,091.5 мянган төгрөгийн 236 мэдээллийг байршуулахаас 64,248,958.1 мянган төгрөгийн 204 мэдээллийг бүрэн мэдээлж, 942,133.4 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Шилэн дансны цахим системд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 599,867.3 мянган төгрөгийн 28 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 342,266.0 мянган төгрөгийн 4 шийдвэрийг тус тус байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4-д *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*, 6.4.8-д *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"* гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагыг хамруулаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус газрыг 2024 оны 7 сард өөрчлөн шинээр байгуулсан тул өмнөх аудитаар гаргаса-зөрчилгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бэлэн мөнгөний орлогын бүртгэл, тайлагнал, түүнд тавих дотоо хяналт, цахилгаан ус дулааны зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг анхаар-үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,367,609.1 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд 139,442.5 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Үндсэн хөрөнгөд 2,228,166.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бүртгэлд авч тайлагнасан.

Аудитаар нийт 57,694.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 569.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 57,125.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 57,694.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 232,703.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Анхан шатны баримтгүй 569.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д *"анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан 569.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилласан бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1.Тайлант онд 12,272.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийн тооцоо хийж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*" 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо хийж актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд 44,853.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийн тооцоо хийж, актаар акбаталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...*" 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо хийж, баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан байна.	1	139,442.5			1	139,442.5	1	139,442.5				
Тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэлд авч, тайлагнаагүй байна.	1	2,228,166.7	1	2,228,166.7			1	2,228,166.7				
Дүн	**1**	**2,367,609.1**	**1**	**2,228,166.7**	**1**	**139,442.5**	**1**	**2,367,609.1**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан байна.	1	569.0	1	569.0								
Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	12,272.7			1	12,272.7						
Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	44,853.0			1	44,853.0						
Дүн	**1**	**57,694.7**	**1**	**569.0**	**2**	**57,125.7**						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 599,867.3 мянган төгрөгийн 28 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 342,266.0 мянган төгрөгийн 4 шийдвэрийг байршуулаагүй байна.	1	942,133.4			1	942,133.4
Дүн	**1**	**942,133.4**			**1**	**942,133.4**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Албан хэрэгцээнд 36,846.0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий 10 аж ахуй нэгжээс худалдан авсан байна.	1	36,846.0			1	36,846.0
Дүн	**1**	**36,846.0**			**1**	**36,846.0**
Нийт дүн	**2**	**978,979.4**			**2**	**978,979.4**

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2025 оны 03 дугаар сарын 14 № 100/А0270164 Улаанбаатар хот

НТАГ-2025/098/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Анхан шатны баримтгүй 569,009.00 (таван зуун жаран есөн мянга ес) төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д *"Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл бөйдал үүссэн"* заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Анхан шатны баримтгүй зарцуулсан 569,009.00 (таван зуун жаран есөн мянга ес) төгрөгийн Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын захирал Д.Жавхлан, ахлах нягтлан бодогч С.Баяржаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН[1]:

АУДИТОР Д.МӨНХДЭЛГЭР

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1465050134

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 04 өдөр Дугаар 343/А022016У Улаанбаатар хот

НТАГ-2025/098/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд 44,852,939.00 (дөчин дөрвөн сая найман зуун тавин хоёр мянга есөн зуун гучин ес) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "зд хөрөнгийн болон төлбөр тооцооны толлого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д *"авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын захирал Д.Жавхлан, ахлах нягтлан бодогч С.Баяржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:

АУДИТОР Д.МӨНХДЭЛГЭР

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040335

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр Дугаар 342/А03701СН Улаанбаатар хот

НТАГ - 2025/098/НА-СТА - ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд 12,272,705.00 (арван хоёр сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун тав) төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын захирал Д.Жавхлан, ахлах нягтлан бодогч С.Баяржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:

АУДИТОР Д.МӨНХДЭЛГЭР

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040333